



“МАТЕРИАЛИМПЭКС” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 04 сарын 30

Дугаар 01

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА СОНГОХ ТУХАЙ


Компанийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.1, хуралд оролцсон нийт гишүүдийн саналыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Материалимпэкс” ХК-ийн Төлөөлөн Удирдах зөвлөлийн даргаар Мэргэд овогт Дагвын Оюуныг 2026 оны 04 дүгээр сарын 30-ны өдрөөс сонгон ажиллуулсугай.
2. Компанийн ирээдүйн хөгжлийн бодлого, чиглэлийг оновчтой тогтоож, түүнийг хэрэгжүүлэхийн тулд хамт олныхоо идэвхийг өрнүүлж, ТУЗ-ийн ажлыг сайжруулан ажиллахыг Д.Оюунд үүрэг болгосугай.



ТУЗ-ИЙН ГИШҮҮД:

 Б.ЗОРИГ

 Д.ОЮУН

 Ш.ГАНЗОРИГ

 П.СУВДАА

 Н.МЯГМАРСҮРЭН

 Э.ПҮРЭВСҮРЭН

 П.АЛТАНЦЭЦЭГ

 С.ЦЭНГЭЛМАА

 М.ХАЙРБЕК



“МАТЕРИАЛИМПЭКС” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 04 сарын 30

Дугаар 02

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫГ ТОМИЛОХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 80 дугаар зүйлийн 80.2, 82 дугаар зүйлийн 82.1 дэх хэсэг, Төлөөлөн Удирдах зөвлөлийн даргын саналыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Материалимпэкс” ХК-ийн Төлөөлөн Удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргаар Т.Лхагвачулууныг томилсугай.

2. Компанийн тухай хууль, компанийн дүрэм, бусад холбогдох хууль, тогтоомжийг мөрдөж ажиллахыг Т.Лхагвачулуунд үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Д.ОЮУН



“МАТЕРИАЛИМПЭКС” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 04 сарын 30

Дугаар 03

Улаанбаатар хот

КОМПАНИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫГ ТОМИЛОХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 80 дугаар зүйлийн 80.2, Компанийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.8 дахь хэсэг, Төлөөлөн Удирдах зөвлөлийн гишүүдийн саналыг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. “Материалимпэкс” ХК-ийн Гүйцэтгэх захирлаар Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүн Дамбийжанцан овогт Баярын **Зоригийг** томилсугай.

2. Б.Зоригтой хууль, дүрэмд заасны дагуу байгуулах гэрээний нөхцөл, түүний ажил үүргийн хуваарь, эрх үүргийн хэмжээ, түүнд олгох цалин хөлс, шагнал урамшуулал, хариуцлагыг тусгаж тодорхойлохыг “Цалин урамшууллын хороо”-нд даалгасугай.

3. Компанийн тухай хууль, компанийн дүрэм, бусад холбогдох хууль, тогтоомжийг мөрдөж, компанийн ирээдүйн хөгжлийн бодлого, чиглэлийг зөв тодорхойлж, түүнийг хэрэгжүүлэхийн тулд хамт олныхоо идэвхийг өрнүүлэн ажиллахыг Б.Зориг-т үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Д.ОЮУН



“МАТЕРИАЛИМПЭКС” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 04 сарын 30

Дугаар 04

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДЭРГЭДЭХ ХОРООДЫН ДАРГА, ГИШҮҮДИЙГ ТОМИЛОХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 80 дугаар зүйлийн 80.2, 81, Компанийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.2.21, 7.3, 7.4, 7.5 дахь хэсэг, Төлөөлөн Удирдах зөвлөлийн гишүүдийн саналыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төлөөлөн Удирдах зөвлөлийн дэргэдэх хороодын дарга, гишүүдийг дараах бүрэлдэхүүнээр томилсугай. Үүнд:

1.1. “Аудитын хороо”-ны даргаар М.Хайрбек, гишүүдэд П.Алтанцэцэг, Н.Мягмарсүрэн нар,

1.2. “Нэр дэвшүүлэх хороо”-ны даргаар С.Цэнгэлмаа, гишүүдэд М.Хайрбек, Ш.Ганзориг нар,

1.3 “Цалин урамшууллын хороо”-ны даргаар П.Алтанцэцэг, гишүүдэд С.Цэнгэлмаа, П.Сувдаа.

2. Хороодын дарга, гишүүд нь хууль, журамд заасны дагуу үйл ажиллагаагаа явуулж, идэвх санаачлага, хариуцлагатай ажиллахыг үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Д.ОЮУН



“МАТЕРИАЛИМПЭКС” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 05 сарын 07-ны өдөр

Дугаар 09

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮНЭЭС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ

Тус компанийн Төлөөлөн Удирдах зөвлөлийн гишүүн Н.Мягмарсүрэн гишүүний сонгуульт ажлаас чөлөөлөгдөх тухай хувийн хүсэлт гаргасан тул,

Компанийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.5, Компанийн “Дүрэм”-ийн 7.2.4 дэх хэсэг, 80 дугаар зүйлийн 80.2 дахь хэсэг, ТУЗ-ийн гишүүдийн саналыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төлөөлөн Удирдах зөвлөлийн гишүүн Ням-Осорын **Мягмарсүрэн**-г 2026 оны 05 дугаар сарын 07-ны өдрөөс сонгуульт ажлаас нь чөлөөлсүгэй.
2. Н.Мягмарсүрэнтэй ажилласан хугацааны тооцоог зохих журмын дагуу хийсүгэй.
3. Н.Мягмарсүрэн ажлаас чөлөөлөгдсөнтэй холбоотой Аудитын хорооны гишүүнээр Э.Пүрэвсүрэнг томилсугай.
4. Төлөөлөн Удирдах зөвлөлийн орлох гишүүний сонгон шалгаруулалтыг дараагийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар шийдвэрлүүлэх ажлыг зохион байгуулахыг Нэр дэвшүүлэх хороонд даалгасугай.
5. “Материалимпэкс” ХК-ийн дараагийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хүртэл хугацаанд Төлөөлөн Удирдах зөвлөл нь 8 гишүүний /ердийн 5, хараат бус 3/ бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаагаа явуулсугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

ТУЗ-ИЙН ГИШҮҮД: ХК



Д.ОЮУН

Б.ЗОРИГ

Ш.ГАНЗОРИГ

П.СУВДАА

Э.ПҮРЭВСҮРЭН

П.АЛТАНЦЭЦЭГ

С.ЦЭНГЭЛМАА

М.ХАЙРБЕК